

## Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ (БОНСУ)



### [Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ \(БОНСУ\)](#)

Састэйнабилити Ийст Эйжия ХХК. 2014. Монгол Улсын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээ. Уул уурхайн яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Уул уурхайн салбар нь Монгол улсын хөгжлийн суурь, эх үүсвэр бөгөөд ирээдүйд мөн энэ хандлага үргэлжлэх төлөвтэй байгаа ч уул уурхайн салбарын хөгжил нь Монгол улсын хөгжилд, түүнчлэн монголчуудын амьдралд яаж нөлөөлөх талаар тодорхой санал нийлсэн алсын хараа харагдахгүй байгаа юм. Энэ асуудалд хариу өгөхөөр Монгол улсын Засгийн газар нь Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээний төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ба тус үнэлгээ нь байгаль орчин, нийгмийн асуудлыг уул уурхайн салбарын шинэчлэлд тусгах замаар Монгол улсын урт удаан хугацааны хөгжилд хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

2013 оны 10-р сард эхлэн 2014 оны 8 сард дууссан энэхүү үнэлгээг Састэйнабилити Ийст Эйжия ХХК гүйцэтгэсэн болно.

Уг БОНСУ-ий гол зорилго нь Монгол улсын тогтвортой бөгөөд олон нийтийн оролцоотой хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүргийн талаар нийтлэг ойлголтыг дээшлүүлэх, уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, бодлогын хүрээнд гарч буй өөрчлөлтүүдийг мэдээлэх, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд уул уурхайн салбарын гүйцэтгэх үүрэг, хувь нэмрийг өсгөх талаар Засгийн газраас гаргаж буй хүчин чармайлтанд дэмжлэг үзүүлэх явдал болно.



**УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН,  
НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ЭЦСИЙН ТАЙЛАН**

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БАЙГАЛЬ  
ОРЧИН, НИЙГМИЙН СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ**

2014 оны 9 сар

